



ДОРНОД АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН  
ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2020 оны 08 дугаар сарын 18 өдөр

Дугаар 44

Хэрлэн сум

ХХХХIV ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Аймгийн Онцгой комиссын 44 дүгээр хурал өргөтгөсөн хэлбэрээр 2020 оны 08 дугаар сарын 18-ны өдрийн 11:00 цагт аймгийн Засаг даргын Тамгын газрын хурлын танхимд 76,6 хувийн ирцтэй хуралдав.

Хурлыг аймгийн Засаг дарга, Онцгой комиссын дарга М.Бадамсүрэн даргалж, холбогдох үүрэг, даалгаврыг өгөв.

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

1. Есүс Христийн хожмын үеийн гэгээнтнүүдийн Чойбалсан цуглаан сүмийн үйл ажиллагааг нээх хүсэлтийг хэлэлцэх,

*Онцгой байдлын газар*

2. Гэрийн ажиглалтад байгаа БНХАУ-ын 31 иргэний удирдах эрх бүхий 5 иргэн Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн 3 дугаар хороонд байрлалтай гэрийн ажиглалтад шилжүүлэх хүсэлтийг хэлэлцэх талаар,

*Эрүүл мэндийн газар*

3. Түр кемпийн нэг байрны барилга угсралтын ажил бүрэн дууссан учир Чойбалсан буудалд гэрийн ажиглалтад байгаа БНХАУ-ын 31 иргэнийг шилжүүлэх хүсэлтийг хэлэлцэх,

*Мэргэжлийн хяналтын газар*

4. "Чойбалсан дулааны цахилгаан станцын суурилагдсан хүчин чадлын 50МВт-аар өргөтгөх төслийн ажлын зураг төсөл боловсруулах, тоног төхөөрөмж нийлүүлэх, барилга угсралтын ажил"-ын хүрээнд БНХАУ-аас 2 дахь ээлжийн 59 инженер техникийн ажилчдыг Замын үүд хилийн боомтоор орж ирж, Чойбалсан хотын Чойбалсан зочид буудалд тусгаарлагдах хүсэлтийг хэлэлцэн шийдвэрлэх,

*Мэргэжлийн хяналтын газар*

5. Иргэн Т.Ариунзул нь 2 хүүхдийн хамт Сэлэнгэ аймгийн Алтанбулаг-Хиагт олон улсын хилийн боомтоор ОХУ-руу нэвтрүүлэх хүсэлт ирүүлснийг хэлэлцэж шийдвэрлэх,

*Онцгой байдлын газар*

6. Онцгой комиссын гишүүдийн саналаар нэмж хэлэлцүүлэх асуудлын талаар,

*Онцгой комиссын гишүүд*

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

1. Монгол Улсын Шадар Сайд, Улсын онцгой комиссын даргын 2020 оны 3 дугаар сарын 14-ний өдрийн Коронавируст халдвар COVID-19-ын үед иргэнийг тусгаарлах, ажиглах түр журмын 9.1, 9.2, 9.4, 9.6 дахь заалтууд, Улсын онцгой комиссын орлогч дарга, Онцгой байдлын ерөнхий газрын даргын баталсан 2020 оны 4 дүгээр сарын 2-ны өдрийн "Гэрийн тусгаарлалт, ажиглалтад байгаа иргэдийн хяналтыг зохицуулах түр

журам”, Эрүүл мэндийн сайдын 2020 оны 269 дүгээр тушаалаар батлагдсан “Ажиглах байрнаас гарсан иргэдийг гэрт нь тусгаарлан үргэлжлүүлэн хянах журам”-ын хэрэгжилтийг хангах, аймгийн Эрүүл мэндийн газар, Мэргэжлийн хяналтын газар, Онцгой байдлын газраас гаргасан саналыг үндэслэн БНХАУ-ын 31 иргэний удирдах албан тушаалын 5 иргэнийг Улаанбаатар хотруу гэрийн ажиглалтад шилжүүлэхгүй байхаар аймгийн Онцгой комиссын гишүүдийн 100 хувийн саналаар дэмжив.

2.”Чойбалсан” зочид буудалд гэрийн ажиглалтад байгаа БНХАУ-ын 31 иргэнийг “ДБЭХС” ТӨХК-ийн хашаанд байрлах түр кемп-д шилжүүлэхийг аймгийн Онцгой комиссын гишүүдийн 100 хувийн саналаар дэмжив.

Нэг. Бүсийн төв Дорнод аймгийн Онцгой байдлын газрын орлогч, Онцгой комиссын нарийн бичгийн дарга, дэд хурандаа Д.Баттулга,  
Мэргэжлийн хяналтын газрын дарга, Онцгой комиссын гишүүн Д.Мөнхтуяа,  
Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн Ч.Оюунаа,  
Цагдаагийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн цагдаагийн хурандаа Т.Ганзориг  
Хэрлэн сумын Засаг даргын орлогч, Онцгой комиссын гишүүн О.Пүрэв-Очир нарт:

1.1. Онцгой байдлын газар, Мэргэжлийн хяналтын газар, Эрүүл мэндийн газар, Цагдаагийн газар, Хэрлэн сумын Засаг даргын Тамгын газар, аймгийн ИТХ-аас бүрдсэн комисс байгуулан, сүм, хийдийн үйл ажиллагаанд КОВИД-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх, халдвар хамгааллын дэглэм, хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт, шалгалт зохион байгуулж, дүнг дараагийн хуралдаанд танилцуулахыг,

Хоёр. Бүсийн төв Дорнод аймгийн Онцгой байдлын газрын орлогч, Онцгой комиссын нарийн бичгийн дарга, дэд хурандаа Д.Баттулга-д

2.1.Холбогдох мэргэжлийн байгууллагууд хамтран “ТВЕА” ХХК-ийн төлөөлөлтэй уулзалт зохион байгуулахыг,

2.2.БНХАУ-аас орж ирэх 2 дахь ээлжийн 59 инженер техникийн ажилчид, хяналтын цэгт үүрэг гүйцэтгэх алба хаагчдын шаардагдах зардлыг “ТВЕА” ХХК гаргаж, БНХАУ-ын 31 иргэнийг “Чойбалсан” зочид буудалд, үлдсэн 28 иргэнийг өөр буудалд байлгахыг зөвшөөрвөл тус компанийн хүсэлтийн дагуу БНХАУ-аас орж ирэх 2 дахь ээлжийн иргэдийг тус аймагт хүлээж авах боломжтой тухай албан бичгийг Улсын онцгой комиссын Шуурхай штаб-д хүргүүлэхийг,

2.3.Иргэн Т.Ариунзулаас ирүүлсэн өргөдөл, хүсэлтийг шийдвэрлүүлэхээр Улсын онцгой комисст албан бичгээр хүсэлт гаргаж хүргүүлэхийг,

Гурав. Хэрлэн сумын Засаг даргын орлогч, Онцгой комиссын гишүүн О.Пүрэв-Очир,  
Цагдаагийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн, цагдаагийн хурандаа Т.Ганзориг,  
Боловсрол, соёл урлагийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн А.Нансалмаа,  
Мэргэжлийн хяналтын газрын дарга, Онцгой комиссын гишүүн Д.Мөнхтуяа,  
Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дарга Э.Жавхлан нарт:


3.1.Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдаж буй Чойбалсан хотын хойд хэсгийн 5,5 км автозамын барилгын ажлын явц удаашралтай байгаа тул нэн түрүүнд сургууль, цэцэрлэгийн орчмын явган хүний болон дугуйн замыг 2020 оны 08 дугаар сарын


30-ны өдөр ашиглалтад бүрэн өгөхийг шаардаж, гүйцэтгэгч компанийн удирдлагад мэдэгдэл хүргүүлэхийг,

Дөрөв. Мэргэжлийн хяналтын газрын дарга, Онцгой комиссын  
гишүүн Д.Мөнхтуяа-д

4.1.Чойбалсан хотын ялалт гүүр /зүүн цементэн гүүр/-ээр Газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээт "Петрочайна Дачин Тамсаг" ХХК-иас албан журмаар ирж байгаа автомашин, иргэнийг шалган нэвтрүүлэхдээ цагийн хуваарийн хязгаарлалтыг тогтоож, шалган нэвтрүүлж байх чиглэлээр тус компанид албан шаардлага хүргүүлэхийг,

4.2.Газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээт "Петрочайна Дачин Тамсаг" ХХК-иас албан журмаар Чойбалсан хотод ирж байгаа автомашин, иргэдийг гүүрээр нэвтрүүлэх цагийн хуваарийн хязгаарлалтыг зохицуулах, шалган нэвтрүүлэх журам боловсруулж, журмын төслийг дараагийн хуралдаанд танилцуулж, батлуулахыг тус тус үүрэг болгов.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА, ОНЦГОЙ КОМИССЫН  
ДАРГА  М.БАДАМСҮРЭН

БҮСИЙН ТӨВ ДОРНОД АЙМГИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН  
ГАЗРЫН ОРЛОГЧ, ОНЦГОЙ КОМИССЫН НАРИЙН БИЧГИЙН  
ДАРГА, ДЭД ХУРАНДАА  Д.БАТТУЛГА